



МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059, Утас: 7037-7121,
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2025. 01. 10 № 1-10/27


танай _____ -ны № _____ Т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Ч.ӨНӨРБАЯР ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2024 оны үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хүргүүлэв.

Хавсралт¹² хуудастай.

ДАРГА



Б.АЗЖАРГАЛ

4525100047



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтэс**

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2024 ОНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

Дархан хот 2024 он

АГУУЛГА

Нэг: ТАНИЛЦУУЛГА

Хоёр: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Гурав: НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Дөрөв: ДҮГНЭЛТ

НЭГ: ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Дархан-Уул аймгийн 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 2 үндсэн чиглэл 45 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 95.28% буюу 4.76 оноотой, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 2.71%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График 1.



ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийн нийт 21 арга хэмжээг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 94.78% буюу 4.73 оноотой байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.27% буюу 0.07 оноогоор буурсан үзүүлэлттэй. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: Нэгтгэсэн төсвийн орлого ба тусламжийн дүн 2024 онд 86,2 тэрбумаас 100,3 тэрбум төгрөгт хүрч 116,3 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 14,1 тэрбум төгрөгөөр давсан ба өмнөх оны гүйцэтгэлээс 36,6 тэрбум төгрөгөөр буюу 157,6 хувиар өссөн нь ОНХСангийн шилжүүлгийн орлого өмнөх оноос 6,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, татварын болон татварын бус орлого давж биелсэнтэй холбоотой байна. Нийт татварын болон татварын бус орлогоор 65,4 тэрбумаас 80,3 тэрбум төгрөг төвлөрч 122.6 хувийн гүйцэтгэлтэй буюу 14,8 тэрбум төгрөгөөр давж биеллээ. Энэ нь татварын бааз суурь тэлсэн, МУЗГ-ын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 40% нэмсэнтэй холбоотой. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийг аймгийн төсөвт төвлөрснөөс орлогын өсөлт бий боллоо.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь зорилтот түвшиндээ хүрч өмнөх оноос давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд эргэн төлөлт 100 хувьтай байна.

Хэрэглээний үнийн индекс, ажилгүйдлийн түвшин хэвийн байгаа ба ажиллах хүчний оролцооны хувь 3.1 хувиар буурсан байна. Эдийн засгийн идэвхитэй хүн амын нийгмийн даатгалд эзлэх хувь 2.7 хувиар өссөн байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ.

График 2.



График 3.



График 4.



ГУРАВ: НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн нийт 24 арга хэмжээг хяналтад авч хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 95.79% буюу 4.78 оноотой байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.52% буюу 0.12 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хувьд хүний хөгжлийн индекс зорилтот түвшинээс 0.09%-иар өссөн, хүн амын дундаж наслалт зорилтот түвшиндээ, эхийн эндэгдэл бүртгэгдээгүй, 1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдлийн түвшин өмнөх оноос 2.3 промилиор буурч, улсын дундажаас 5.3 промилиар бага, PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж зорилтот түвшинээс 39м.кг/т3, өмнөх оны мөн үеэс 7м.кг/м3-аар буурсан сайн үзүүлэлттэй байгаа бол жендэрийн тэгш бус байдлын индекс 0.003%-иар өссөн, PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж, зорилтот түвшинээс 2м.кг/м3-иар өссөн, вирус гепатитын өвчлөлийн 6 тохиолдол бүртгэгдэж урьд оноос 0.41 промилиор өссөн, гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3%-иар өссөн нь муу үзүүлэлт боловч иргэдэд учирсан нөхөн төлүүлэлтийн түвшин өссөн сайн үзүүлэлт байна.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

График 5.





График 6



ДӨРӨВ: ДҮГНЭЛТ

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 2891 дугаар албан бичгийн хавсралтын дагуу зорилтот түвшинг 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулж, тайлбар гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. 2021-2024 оны зарим нэг зорилтот түвшин нь гүйцэтгэл гаргахад учир дутагдалтай байна. Тухайлбал:

Хүснэгт 1.

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин					Бодит гүйцэтгэл	Үнэлгээ,%
			2019/2020	2021	2022	2023	2024	2024		
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ										
3	Төсвийн орлого	сая төгрөг	30,235.20	30,606.40	30,637.80	30,650.40	30,656.70	100,313.10	100	
4	Төсвийн зардал	сая төгрөг	28,411.20	27,920.00	33,164.60	33,177.20	33,183.50	99,793.40	33.25	
5	Төсвийн тэнцэл	сая төгрөг	1,824.00	2,686.40	-2,526.80	-2,526.80	-2,526.80	519.70	100	
18	Хүлээн авах гадаад жуулчид	тоо	0	0	10	30	50	4663	100	
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ										
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	540	760	750	735	720	982	73.32	
29	Ойгоор бүрхэгдсэн тайлбайн эзлэх хувь	хувь	2.20	2.22	2.24	2.26	2.29	2.30	100	

Дээрх 4 жилийн зорилтот түвшинг хүн амын тоотойгоо уялдуулан төсөөллөөр гаргаагүй нь гэмт хэргийн гаралт ихсэх үзүүлэлт жил бүр нэмэгдсэн, бага хувийн үзүүлэлтийн нэг болоод байна. Мөн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг тухайн оны өсөлттэй уялдуудан зөвхөн өсөлтийн хувиар гаргасан нь учир дутагдалтай байна. Манай аймгийн хэмжээнд ойн сангийн 81997 га талбай байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг эзэлж байна.

Нийт татварын болон татварын бус орлогоор 65459,8 сая төгрөгөөс 80289,4 сая төгрөг төвлөрч 122.6 хувийн гүйцэтгэлтэй буюу 14829,6 сая төгрөгөөр давж биелсэн.

Энэ нь татварын бааз суурь тэлсэн, МУЗГ-ын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 40-60 хувь нэмсэнтэй холбоотой ХХОАТ-ын орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлснээр орлого өссөн.

Ийнхүү аймгийн төсвийн нийт зарлага 109,8 тэрбум төгрөгөөс 81,5 тэрбум төгрөг буюу 74,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал зардал 91,3 хувь, хөрөнгийн зардал 58,5 хувийн тус тус гүйцэтгэлтэй. Аймаг, сумдын татварын орлогын биелэлттэй уялдуулан сумаас аймагт төвлөрүүлэлт 38,2 тэрбум төгрөг, сумдад олгох санхүүгийн дэмжлэг 1,9 тэрбум төгрөгийг бүрэн олгож, батлагдсан төсвийн хүрээнд улсын төсөвт төвлөрүүлэх 1,3 тэрбум төгрөг, дамжуулан зээлийн өр 3,6 тэрбум төгрөгийг тус тус бүрэн төвлөрүүлж, 2024 оны давсан орлого, урсгал зардлын хэмнэлтээс дамжуулан зээлийн өр төлбөрт 18,2 тэрбум төгрөгийг суутгуулан төлж барагдуулсантай холбоотой зарлагын өсөлт бий боллоо.

Цаашид эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 4 жилээр гаргахад статистикийн нарийн тооцоо судалгаан дээр үндэслэн, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харьцуулан, тухайн орон нутгийн түвшинд зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг гарган батлах шаардлагатай байна.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ТАНИЛЦУУЛГА ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be "Г.Гэрэлмаа".

Г.ГЭРЭЛМАА

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 он

Аймаг, нийслэлийн нэр: ДАРХАН-УУЛ АЙМАГ

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт 2023	Зорилтот түвшин 2024	Гүйцэтгэл		Үнэлгээ, хувь	Тайлбар
					2024	2024		
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ								
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	943.086.4	943.086.4	1,043,086.00	100	Аймгийн Статистикийн хэлтэс.(2022 он 755,747.3, 2023 он 943,086.4, 2024 он хүлээгдэж буй гүйцэтгэл)	
2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	сая төгрөг	9.077.3	6,189.80	9,680.00	100	Аймгийн Статистикийн хэлтэс.(2022 он 7,222.08, 2023 он 9,077.3, 2024 он хүлээгдэж буй гүйцэтгэл)	
3	Төсвийн орлого	сая төгрөг	63,359.40	30,656.70	100,313.10	100	Нэгтгэсэн төсвийн орлого ба тусламжийн дүн 2024 онд 86,2 тэрбумаас 100,3 тэрбум төгрөгт хүрч 116,3 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 14,1 тэрбум төгрөгөөр давсан ба өмнөх оны гүйцэтгэлээс 36,6 тэрбум төгрөгөөр буюу 157,6 хувиар өссөн нь ОНХСангийн шилжүүлгийн орлого өмнөх оноос 6,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, татварын болон татварын бус орлого давж биелсэнтэй холбоотой байна. Нийт татварын болон татварын бус орлогоор 65,4тэрбумаас 80,3 тэрбум төгрөг төвлөрч 122.6 хувийн гүйцэтгэлтэй буюу 14,8 тэрбум төгрөгөөр давж биеллээ. Энэ нь татварын бааз суурь тэлсэн, МУЗГ-ын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 40% нэмсэнтэй холбоотой. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийг аймгийн төсөвт төвлөрснөөс орлогын өсөлт бий боллоо.	
4	Төсвийн зардал	сая төгрөг	52,149.20	33,183.50	99,793.40	33.25	Аймгийн төсвийн нийт зарлага 109,8 тэрбум төгрөгөөс 81,5 тэрбум буюу 74,2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал зарлага 91,3 хувь, хөрөнгийн зардал 58,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймаг, сумдын татварын орлогын биелэлтэд уялдуулан сумаас аймагт төвлөрүүлэлт 38,2 тэрбум төгрөг, сумдад олгох санхүүгийн дэмжлэг 1,9 тэрбум төгрөг бүрэн олгож батлагдсан төсвийн хүрээнд улсын төсөвт төвлөрүүлэх 1,3 тэрбум төгрөг, дамжуулан зээлийн өр 3,6 тэрбум төгрөг бүрэн төвлөрүүлж, 2024 оны давсан орлого, урсгал зардлын хэмнэлтээс дамжуулан зээлийн өр төлбөрт 18,2 тэрбум төгрөгийг суутгуулан төлж барагдуулсантай холбоотой зарлагын өсөлт бий боллоо.	

5	Төсвийн тэнцэл	сая төгрөг	11,210.20	-2,526.80	519.70	100	37 төслийн, 32 аж ахуйн нэгжийн 90.591.390 төгрөгийн орлогыг ЖДҮХ сан-100900037019 тоот дансанд төвлөрүүлсэн. 2018-2023 онд ийт 37 төсөлд 5.2 тэрбум төгрөг олгосноос 1 ААН эргэлзээтэй ангилалд, 31 ААН эргэн төлөлт хэвийн ангилалд буюу 97%-тай байна. Энэ нь өмнөх оноос 10% нэмэгдсэн байна.
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлт	хувь	92.45	90.0	97.3	100	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 445 дугаар хорих анги, Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхтэй хамтран өр төлбөр барагдуулах аяныг 2024 онд 2 удаа зохион байгуулсан.
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт	хувь	80	90.0	90	100	Эх сурвалж: Аймгийн статистикийн хэлтэс. Зорилтот түвшингээс 0.6 хувиар, буурсан бол өмнөх оноос 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
8	Ажилгүйдлийн түвшин	хувь	12.9	12.6	12	100	Аймгийн Статистикийн хэлтэс.(2022 он 53.6, 2023 он 53.3, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл)
9	Ажиллах хүчний оролцоо	хувь	53.3	59.0	55.9	94.74	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бодлого төлөвлөлтийн хэлтэс
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт	хувь	88	90.0	72.2	80.22	Эх сурвалж: Аймгийн статистикийн хэлтэс. Зорилтот түвшингээс 2.7 хувиар өссөн байна.
11	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд эзлэх хувь	хувь	80.6	76.0	78.7	100	Эх сурвалж: ХХҮГ. Зорилтот түвшнээс байнгын ажлын байрны тоо 700-оор нэмэгдсэн нь хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөнтэй уялдаатай.
12	Шинээр бий болгосон байнгын ажлын байр	тоо	2100	1500	2200	100	Эх сурвалж: Аймгийн Статистикийн хэлтэс
13	Хэрэглээний үнийн индекс	индекс	11.7	11.4	11.4	100	Засгийн газрын 2018 оны "Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай" 131 дүгээр тогтоолыг үндэслэн малын тоо толгойг 18.01 хувь буюу 67.39 тоо толгойгоор бууруулсан үзүүлэлттэй,
14	Малын тоо	мянган толгой	261.3	374.2	252.2	100	Зорилтот түвшнээс 4.1 мянган тонноор өссөн бол өмнөх оны мөн үеэс 4.7 мянган тонноор буурсан үзүүлэлттэй байна.Энэ нь хөрсний утгвар чийг хангалттай байсан хэдий ч 6 дугаар сарын 10 хоногоос 7 дугаар сарын 10 хоног хүртэл хур тунадас ороогүй тул үр тарианы бутлалтаас түрүүлэлтийн үе шатандаа чийг бага байсантай холбоотой.
15	Хураан авсан үр тариа	мянган тонн	20.8	12.0	16.1	100	Эх сурвалж: Аймгийн статистикийн хэлтэс. Зорилтот түвшингээс 0.67 хувиар өссөн байна.
16	Хураан авсан малын тэжээл бусад	мянган тонн	3.0	1.2	1.87	100	Эх сурвалж: Аймгийн статистикийн хэлтэс. Зорилтот түвшингээс 13.5 хувиар өссөн байна.
17	Хураан авсан хүнсний ногоо	мянган тонн	25.6	21.0	34.5	100	

18	Хүлээн авах гадаад жуулчид	тоо	3705	50	4663	100	2024 оны III улирлын байдлаар: Аймгийн Статистикийн хэлтэс
19	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага	тоо	2121	2830	2331	82.36	2024 оны III улирлын байдлаар: Аймгийн Статистикийн хэлтэс
20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	57.3	58.0	58.2	100	ХБТХОХ
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	91.7	89.7	94.3	100	ЗАА
Нийт үнэлгээ, хувь							
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ							
22	Хүн амын дундаж наслалт	нажилт	68.59	68.98	68.98	100	Аймгийн Статистикийн хэлтэс: 2024 он 68.98 насжилт
23	Хүний хөгжлийн индекс	индекс	0.773	0.71	0.8	100	Аймгийн Статистикийн хэлтэс: 2024 он 0.8 индекс
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	индекс	0.831	0.832	0.835	99.64	Аймгийн Статистикийн хэлтэс: 2024 он 0.835 индекс
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	714	720	982	73.32	Цагдаагийн газар цагаан мэдээ: 2024 оны жилийн эцсийн мэдээ
26	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	хувь	50.9	42.5	68.1	100	Цагдаагийн газар цагаан мэдээ: 2024 оны жилийн эцсийн мэдээ
27	PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	м кг/м3	90	80	82	97.56	УЦУОШТөв.
28	PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	м кг/м3	58	90	51	100	УЦУОШТөв.
29	Ойгоор бүрхэгдсэн тайлбайн эзлэх хувь	хувь	2.28	2.29	2.30	100	Дархан-Уул аймгийн нийт газар нутгийн хэмжээ 327.5 мян.га талбайтай. Ойн сангийн талбай 81997 га энэ нь нийт нутаг дэвсгэрийн 25 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 0.01 хувиар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.
30	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	2.0	1.6	1.5	93.75	ХБТХОХ, ЗАА
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	8.0	9.0	9.1	100	Хүн амын өсөлттэй холбоотой хогны хэмжээ нэмэгдсэн, мөн татан авалт нэмэгдсэн, хог хаягдлаа бүрэн зайлуулж байна.

32	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	промиль	0.0	0.0	0.0	100	Тохиолдол бүртгэгдээгүй
33	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промиль	8.2	9.45	6.6	100	Урьд оны мөн үеэс 2.3 промиль буурсан үзүүлэлттэй байна. Улсын дунджаас 5.3 промиль бага буюу сайн үзүүлэлттэй. /Улсын дундаж 11.9 промиль/
34	10,000 хүн амд вирус гепатитын өвчлөл	тоо	0.09	0.6	0.5	83.33	Вируст гепатитын өвчлөлийн 6 тохиолдол бүртгэгдэж урьд оноос 0.41 промиль өссөн үзүүлэлттэй байна.
35	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	99.7	99.6	99.5	99.89	Дархлаажуулалтад хамрагдвал зохих хүүхэд 23352, хамрагдсан 23236. Урьд оноос 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
36	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралт	хувь	97.2	98	94.6	96.53	18-аас дээш насны 65156 хүн хамрагдахаас 61638 хамрагдсан. Урьд оны мөн үетэй харьцуулахад 2.6 хувиар буурсан байна.
37	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	97.01	98	91.2	93.06	Чихрийн шижингийн хамрагдалтын насанд өөрчлөлт орсонтой холбоотой хамрагдалтын хувь буурсан. 40-өөс дээш насныхан хамрагддаг байсан бол 2024 оноос 18 дээш нас хамрагддаг болсон. Нийт 65156 хүн хамрагдахаас 59423 хүн хамрагдсан. Урьд оны мөн үетэй харьцуулахад 5.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралт	хувь	85.3	85	87.4	100	Өмнөх оноос 2.1 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна.
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	95.1	93	100	100	Цэцэрлэгийн насны хүүхдийн статистик тоо 8592, СӨББ-д 2024-2025 онд хамрагдаж байгаа хүүхдийн тоо 8631.
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	100	100	85.5	85.5	Суурь боловсрол эзэмших насны хүн амын статистик тоо 10771, суурь боловсролд хамрагдаж буй хүний тоо 9216.
41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	27.6	25.5	29.8	85.57	СӨББ-д хамрагдаж буй хүүхдийн тоо 8172, цэцэрлэгийн бүлгийн багшийн тоо 274. Шилжих хөдөлгөөнтэй холбоотой нэг багшид ногдох хүүхдийн тоо 2.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	33.4	30	33	90.9	Бага боловсролд хамрагдаж буй сурагчдын тоо 12715, бага ангийн багшийн тоо 385.
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	525	525	535.4	100	2024 оны хаврын элсэлтийн шалгалтын дүн
44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах оюутан	тоо	48	25	45	100	БХС-ын тушаалаар Дархан-Уул аймагт оюутан цэргийн бэлтгэл сургалтын хяналтын тоогоор 40 оюутан залуусыг бэлтгэх байсан боловч оюутан залуусын хүсэлтийн дагуу 5 иргэнийг нэмэгдүүлэн хүлээн авч бэлтгэсэн болно.

45	Төрийн цахим үйлчилгээний тоо	Тоо	440	183	586	100	Цахим шилжилтийг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлж, цахим үндэстэн болох зорилтын хүрээнд төрийн үйлчилгээг олон нийтэд хүргэж, "Цахим аймаг", "Ухаалаг хот" арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлэн, аймагтаа 10 цахим систем нэвтрүүлж, иргэд, аж ахуй нэгжүүдийн цахим хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтийг хамарсан сургалт семинар, мэдээллийн ажлууд, нөлөөллийн ажлуудыг авч хэрэгжүүлснээр өмнөх оны түвшнээс 4 дахин өссөн сайн үзүүлэлттэй байна.
----	-------------------------------	-----	-----	-----	-----	-----	--

Нийт үнэлгээ, хувь 95.79% буюу 4.78 оноо

ЕРӨНХИЙ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 95.28% буюу 4.76 оноо



ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Б. АЗЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

П. БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Г. ГЭРЭЛМАА

Гш